

“VOO” ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

/Хувь хэрэглэгч/

НЭГ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

1.1 Энэхүү үйлчилгээний нөхцөл нь интернэт орчинд гар утас, таблет, компьютер, телевиз зэрэг ухаалаг төхөөрөмжүүд дээр гадаад, дотоодын кино, контент, телевизийн сувгуудыг үзэх боломжийг олгож буй “VOO” үйлчилгээг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Шинэ хэрэглэгч болох

- 1.2.1. Хэрэглэгч интернэтэд холбогдсон төхөөрөмж дээр VOO үйлчилгээг ашиглана.
- 1.2.2. VOO үйлчилгээг ашиглах тохиромжтой интернэт үйлчилгээний хурд 5 mbps-ээс багагүй байна.
- 1.2.3. Хэрэглэгч “Өрхийн интернэт болон VOO үйлчилгээний төхөөрөмж зээлээр болон хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдах, худалдан авах, үйлчилгээний багц ашиглах хугацаатай гэрээ” байгуулан нэг VOO төхөөрөмж авах эрхтэй.
- 1.2.4. Хэрэглэгч нэмэлтээр VOO төхөөрөмжийг худалдан авч ашиглах тохиолдолд төхөөрөмжийн төлбөрийг төлнө.

1.3 Үйлчилгээний хугацаа

- 1.3.1. VOO үйлчилгээний гэрээ нь хугацаатай болон хугацаагүй гэсэн хоёр төрөл байна.
- 1.3.2. Хугацаатай гэрээ нь Хэрэглэгч VOO төхөөрөмжийг энэхүү нөхцөлд заасан нөхцөлийн дагуу авч, сонгосон VOO үйлчилгээний багцыг “Өргөдлийн маягт” болон “Өрхийн интернэт болон VOO үйлчилгээний төхөөрөмж зээлээр болон хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдах, худалдан авах, үйлчилгээний багц ашиглах хугацаатай гэрээ” дээр заасан хугацаанд тогтмол ашиглахыг ойлгоно.
- 1.3.3. Хугацаагүй гэрээ нь Хэрэглэгч энэхүү үйлчилгээний нөхцөл болон гэрээг хүлээн зөвшөөрч, талууд гарын үсэг зурж баталгаажуулан хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар болон хэрэглэгчийн хүсэлтээр үйлчилгээ цуцлагдах хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.4 Багцын сарын хураамж

- 1.4.1. Багцын сарын хураамж нь VOO үйлчилгээ ашигласны төлбөр бөгөөд хэрэглэгч Хавсралт 1.1-д заасан багцуудаас сонгон ашиглах боломжтой.
- 1.4.2. Багцын сарын хураамж болон Хавсралт 1.2-т заасан нэмэлт үйлчилгээний хураамж нь доорх нөхцөлүүдээс бусад тохиолдолд сар бүр нэхэмжлэгдэнэ. Үүнд:
 - 1.4.2.1. Хэрэглэгч үйлчилгээг хадгалуулсан.
 - 1.4.2.2. Хууль болон гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэгчийн санаачилгаар хэрэглэгчийн үйлчилгээг бүхэлд нь зогсоосон.
 - 1.4.2.3. Хэрэглэгч албан ёсоор үйлчилгээ үзүүлэгчид хандаж үйлчилгээг цуцалсан.
- 1.4.3. Хэрэглэгч тухайн сардаа хэрэглээ хийсэн эсэхээс үл хамааран сонгосон багцын сарын хураамжийг тогтмол нэхэмжилнэ.
- 1.4.4. Төлбөр төлөөгүйн улмаас үйлчилгээний эрхээ хаалгасан хэрэглэгчийн тухайн сарын хураамжийг бүтэн нэхэмжилнэ.
- 1.4.5. Хугацаатай гэрээний нөхцөлөөр үйлчилгээ авсан хэрэглэгч “Өргөдлийн маягт” болон “Өрхийн интернэт болон VOO үйлчилгээний төхөөрөмж зээлээр болон хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдах, худалдан авах, үйлчилгээний багц ашиглах хугацаатай гэрээ” дээр заасан хугацаанд үйлчилгээг тасралтгүй ашиглах ба энэхүү хугацаанд үйлчилгээний багцын сарын хураамжийг тогтмол нэхэмжилнэ.
- 1.4.6. Шинэ хэрэглэгч нь хуанлийн сарын дундуур гэрээ байгуулсан тохиолдолд багцын сарын хураамжийг тухайн сарын үлдэгдэл хоногт дүйцүүлэн тооцож нэхэмжлэх бөгөөд дараа сараас багцын сарын хураамжийг тогтмол нэхэмжилнэ.

ХОЁР. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Хэрэглэгч нь гэрээ байгуулахаас өмнө үйлчилгээ ашиглахад шаардлагатай интернэт орчинг бүрдүүлж бэлэн болгосон байна.
- 2.2 Хэрэглэгчийн интернэт сүлжээ болон түүнд ашиглаж байгаа төхөөрөмжөөс шалтгаалан гарсан аливаа гэмтэл саатал болон өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас гарсан гэмтэл хоцрогдлыг хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.
- 2.3 Хэрэглэгч VOO үйлчилгээг зөвхөн өрхийн буюу хувийн хэрэглээний зориулалтаар ашиглах эрхтэй.
- 2.4 Нэвтрэх нэр, нууц үгээ бусдад дамжуулсан болон алдсанаас болж үүсэх аливаа асуудлыг хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.
- 2.5 Хэрэглэгч уг үйлчилгээний нөхцөлийн 5.5.1-д заасан Эцэг эхийн хяналтын кодоо хамгаалах, бусдад дамжуулахгүй байх үүрэгтэй бөгөөд уг үүргээ биелүүлээгүйгээс үүдэн гарах аливаа асуудлыг хэрэглэгч өөрөө бүрэн хариуцна.
- 2.6 Хэрэглэгч VOO үйлчилгээнд бүртгэлтэй үүрэн холбооны дугаараа бусдад шилжүүлэх тохиолдолд үйлчилгээний бүртгэлээс хаасаж дахин өөр дугаар бүртгүүлэх үүрэгтэй.
- 2.7 VOO үйлчилгээгээр дамжуулан үзэж буй кино, контент, телевизийн нэвтрүүлгүүд, үзвэрүүд, тоглолтын бичлэг болон бусад оюуны өмчийн материалуудыг холбогдох эрх эзэмшигчдийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, түгээх, арилжааны зорилгоор ашиглах, эдгээртэй адилтгах бусад хууль бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 2.8 Хэрэглэгч гэрээ цуцлах тохиолдолд зөвхөн өөрийн биеэр цахим үнэмлэхтэйгээ үйлчилгээний салбарт ирнэ.

2.9 Хугацаатай гэрээ байгуулан “Өрхийн интернэт болон VOO үйлчилгээний төхөөрөмж зээлээр болон хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдах, худалдан авах, үйлчилгээний багц ашиглах хугацаатай гэрээ”-ний нөхцөлөөр VOO төхөөрөмж авсан хэрэглэгч өргөдлийн маягт дээр болон гэрээнд заасан хугацаанаас өмнө үйлчилгээ цуцлах тохиолдолд 4.1.4-д заасан төлбөрийг төлж барагдуулна.

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Үйлчилгээ үзүүлэгч нь аливаа техникийн гэмтэл, гэнэтийн саатал гарсан тохиолдолд хурдан шуурхай засварлах, үйлчилгээг техникийн боломж хүчин чадлын хүрээнд стандартын дагуу чанартай үзүүлэх үүрэгтэй.
- 3.2 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний төлбөр бүрэн төлөгдсөн тохиолдолд хэрэглэгчийн үйлчилгээний эрхийг нээх үүрэгтэй.
- 3.3 Үйлчилгээ үзүүлэгч нь веб болон аппликейшний бүтэц, видео сан, телевизийн сувгийг өөрчлөх эрхтэй.
- 3.4 Хэрэглэгч өрхийн буюу хувийн хэрэгцээнээс бусад зорилгоор үйлчилгээг ашигласан тохиолдолд үйлчилгээг зогсоож, гэрээг цуцлах эрхтэй.
- 3.5 Оюуны өмчийн эрхийг зөрчсөн сувгийг хаах, нэвтрүүлэхгүй байх эрхтэй.
- 3.6 Үйлчилгээ үзүүлэгч нь VOO үйлчилгээгээр дамжуулан үйлчилгээний болон сурталчилгааны мэдээлэл хүргэх эрхтэй.
- 3.7 Хэрэглэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд зөвхөн үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран хэрэглэгчийн мэдээллийг ашиглах эрхтэй.
- 3.8 Хэрэглэгч үйлчилгээний төлбөрөө хугацаандаа төлөөгүй болон гэнэтийн гэмтэл саатлын улмаас үйлчилгээ доголдсон тохиолдолд үйлчилгээг түр хаах эрхтэй.

ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1 Төлбөрийн нэхэмжлэх
 - 4.1.1 Үйлчилгээ үзүүлэгч нь үйлчилгээний төлбөрийг сарын 01-нээс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 05-ны дотор Хэрэглэгчээс нэхэмжилнэ.
 - 4.1.2 Төлбөрийн нэхэмжлэх нь тухайн сарын багцын хураамж, нэмэлт үйлчилгээний нийлбэр дүнгээс зохих хөнгөлөлтийг хасаж тооцсоны дараах дүн, өмнөх сарын төлбөрийн үлдэгдэл, НӨАТ зэргээс бүрдэнэ.
 - 4.1.3 Хэрэглэгч нь 4.1.1-д заасан төлбөрийг нэхэмжилсэн сарын 20-ны дотор үлдэгдэлгүй, бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
 - 4.1.4 Хугацаатай гэрээ байгуулан хөнгөлөлттэй нөхцөлөөр VOO төхөөрөмж авсан хэрэглэгчээс дараах тохиолдолд төхөөрөмжийн үндсэн үнийг бүтэн нэхэмжилнэ. Үүнд:
 - 4.1.4.1 Хэрэглэгч төлбөрөө төлөөгүйн улмаас үйлчилгээ хаагдсан өдрөөс хойш 2 сар өнгөрсөн бол;
 - 4.1.4.2 Хугацаанаасаа өмнө гэрээгээ цуцалсан бол.
 - 4.1.5 Хэрэглэгч VOO үйлчилгээний төлбөрөө төлөөгүйн улмаас үйлчилгээ хаагдсан бол үйлчилгээний төлбөрөө бүрэн барагдуулсан тохиолдолд үйлчилгээний эрх нь нээгдэнэ.
 - 4.1.6 Хэрэглэгч нь үйлчилгээний төлбөрөө үйлчилгээ үзүүлэгчийн заасан банкны дансаар, www.voo.mn, VOO аппликейшн болон бусад боломжит сувгаар төлнө.

ТАВ. НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

- 5.1 Хэрэглэгчийн сонгон ашиглаж байгаа багцын дагалдах эрхэд хамаарахгүй, багцын төлбөр дээр нэмэлт төлбөр төлж ашиглах боломжтой Хавсралт 1.2-д заасан нэмэлт үйлчилгээнүүд байна.
- 5.2 Хэрэглэгч VOO төхөөрөмж болон аппликейшнаас нэмэлт үйлчилгээг үйлчилгээг идэвхжүүлэх боломжтой бөгөөд үйлчилгээ идэвхжүүлсэн сарын хураамжийг ашигласан өдөрт нь дүйцүүлэн тухайн сарын багцын төлбөр дээр нэхэмжилнэ.
- 5.3 Хэрэглэгч нэмэлт үйлчилгээг цуцлах хүртэл сар бүр автоматаар сунгагдах бөгөөд үйлчилгээний төлбөр сар бүр бүрэн нэхэмжлэгдэнэ.
- 5.4 Хэрэглэгч нэмэлт үйлчилгээг цуцлах хүсэлтээ дараах сувгаар хандан өгөх боломжтой:
 - 5.4.1 Үйлчилгээний салбарт.
 - 5.4.2 Үйлчилгээний нэгдсэн төв (Мобикомын дугаартай хэрэглэгч бол 2288, бусад сүлжээнээс 75952288).
- 5.5 Хавсралт 1.2-д зааснаас бусад нэмэлт үйлчилгээ:
 - 5.5.1 Эцэг эхийн хяналтын код:
 - 5.5.1.1 Нэмэлт төлбөртэй үйлчилгээ идэвхжүүлэх үед ашиглана.
 - 5.5.1.2 Үйлчилгээний багц солих үед ашиглана.
 - 5.5.1.3 Насны хязгаар (+18) заасан кино, контент, телевизийн суваг үзэхээр хандах үед эцэг эхийн хяналтын кодоор хязгаарлана.
 - 5.5.1.4 Эцэг эхийн хяналтын кодыг хэрэглэгч хүссэн үедээ ТВ, аппликейшн, вэб сайтаар хандан сэргээх, солих боломжтой.
- 5.6 Нөхөж, ухрааж үзэх үйлчилгээ:
 - 5.6.1 Хавсралт 1.1-д заасан багцад нөхөж, ухрааж үзэх үйлчилгээ үнэгүй дагалдана.
 - 5.6.2 Телевизийн хөтөлбөрийг 96 цаг хүртэл хугацаагаар нөхөж үзэх.
 - 5.6.3 Шууд дамжуулагдаж байгаа телевизийн хөтөлбөрийг 2 цаг хүртэл хугацаагаар ухрааж үзэх.

5.6.4 Суваг нийлүүлэгчийн хүсэлтээр дотоод болон гадаадын зарим телевизийн сувгийн хөтөлбөрийг нөхөж, ухрааж үзэх боломжгүй байна.

ЗУРГАА. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

- 6.1 Хэрэглэгчийн хүсэлтээр гэрээ цуцлах:
 - 6.1.1 Хугацаагүй гэрээтэй хэрэглэгчийн гэрээ цуцлах хүсэлтийг тухайн сарын төлбөрийн нэхэмжлэх бодогдсон хугацаанаас хойш хүсэлт гаргасан өдөрт нь гүйцэтгэж, багцын сарын хураамжийг үйлчилгээ цуцлах өдрийг хүртэлх ашигласан хоногт дүйцүүлэн тооцно.
 - 6.1.2 Хугацаатай гэрээ байгуулан V00 төхөөрөмж авсан хэрэглэгч гэрээний хугацаа дуусахаас өмнө гэрээ цуцлах тохиолдолд "Өрхийн интернэт болон V00 үйлчилгээний төхөөрөмж зээлээр болон хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдах, худалдан авах, үйлчилгээний багц ашиглах хугацаатай гэрээ" болон "Өргөдлийн маягт" дээр заасан төхөөрөмжийн төлбөрийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлж барагдуулна.
 - 6.1.3 Хэрэглэгч гэрээ цуцлах өдрийг хүртэлх ашигласан үйлчилгээний төлөгдөөгүй бүх төлбөрийг төлж барагдуулна.
 - 6.1.4 Хэрэглэгч нь гэрээ цуцлах өдрийг хүртэлх хугацаанд ашигласан үйлчилгээний төлбөрийг бүрэн барагдуулах үүрэгтэй.
- 6.2 Үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс гэрээ цуцлах
 - 6.2.1 Үйлчилгээ үзүүлэгч дараах тохиолдолд үйлчилгээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:
 - 6.2.1.1 Төлбөрөө төлөөгүй хэрэглэгчийн үйлчилгээг 3 сар хадгалан 4 дэх сард;
 - 6.2.1.2 Хадгалах үйлчилгээ авсан хэрэглэгч 4.1.3-д заасан хугацаанд төлбөрийн үлдэгдлээ барагдуулаагүй бол үйлчилгээ автоматаар нээгдэх сард.
 - 6.2.1.3 Хэрэглэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн бол;
 - 6.2.1.4 Хэрэглэгч өргөдлийн маягтын мэдээллийг худал мэдүүлсэн бол;
 - 6.2.1.5 Үйлчилгээ үзүүлэгчийн бусад үйлчилгээнд төлбөрийн маргаантай бол;
 - 6.2.1.6 Захиалга өгснөөс хойш 21 хоногийн хугацаанд хэрэглэгчээс шалтгаалан холболт хийгдээгүй тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран холболтын захиалгыг цуцлах эрхтэй.

“VOO” ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ
/Хувь хэрэглэгч/

ХАВСРАЛТ 1

1.1 Багцын үнэ тариф

Багцын нэр	TV	Content	Premium	Premium plus
Багцын сарын хураамж	9'900₮*	9'900₮	19'900₮*	29'900₮*
Нэг агшинд зэрэг үзэх эрх	2 (STB + Утас**)			
Дотоодын суваг	Дагалдана	-	Дагалдана	Дагалдана
Гадаад суваг				
Төлбөргүй контент үзэх эрх	-	Дагалдана		
PSN спорт багц	7'900₮			
HBO багц	7'900₮			
Караоке	3'900₮			
Насанд хүрэгчдийн суваг	7'900₮			

* Өргөн нэвтрүүлгийн ТВ үйлчилгээний хөлс 2'500₮ (НӨАТ-тай) нэмж тооцогдоно.
** Утас гэдэгт таблет, ухаалаг утас, вэбээр үзэх дэлгэц хамаарна.

1.2 Нэмэлт үйлчилгээний нөхцөл, үнэ тариф

Нэмэлт үйлчилгээ	Нөхцөл	Идэвхжүүлэх суваг	Цуцлах суваг	Үнэ тариф /Нэхэмжлэх/	
Premier sports (PSN)	• Төлбөртэй сувгийг хэрэглэгч сард 1 удаа идэвхжүүлэх болон цуцлах боломжтой. Цуцлах хүртэл үйлчилгээг сар бүр автоматаар сунгана.	<ul style="list-style-type: none"> • VOO төхөөрөмж • VOO аппликейшн • www.voo.mn веб сайт 	<ul style="list-style-type: none"> • Үйлчилгээний салбарт • 2288 үйлчилгээний нэгдсэн төвд (Бусад сүлжээнээс 75952288 дугаарт) хандах 	7'900₮	Ашигласан өдөрт нь дүйцүүлэн тухайн сарын багцын төлбөр дээр нэхэмжилнэ.
HBO багц	• TV, Premium багцад зөвхөн HBO HD суваг үнэгүй дагалдана.			7'900₮	
Караоке	• Дууны цуглуулга идэвхжүүлэн ашиглах боломжтой үйлчилгээ.			3'900₮	
Насанд хүрэгчдийн суваг	• (+18) контент дамжуулах телевизийн суваг.			7'900₮	
VOO cinema	• Гадаад болон дотоодын шилдэг кино контент түрээслэн үзэх боломжтой;		<ul style="list-style-type: none"> • VOO төхөөрөмж • VOO аппликейшн 	9'900₮	Түрээсэлсэн кино, контент тус бүрийн төлбөрийг VOO үйлчилгээний төлбөр дээр нэхэмжилнэ.
Нэмэлт дэлгэц	• Түрээсэлсэн контентын хүчинтэй хугацаа 72 цаг байна.	10'000₮		Гурав хүртэлх нэмэлт дэлгэц идэвхжүүлэн ашиглах боломжтой байна. Үйлчилгээг ашигласан өдөрт нь дүйцүүлэн тухайн сарын багцын төлбөр дээр нэхэмжилнэ.	
	• Premium багцтай хэрэглэгч /нэг нэмэлт дэлгэц/	5'000₮			
	• Premium plus багцтай хэрэглэгч /нэг нэмэлт дэлгэц/				
	• Content багцтай хэрэглэгч /нэг нэмэлт дэлгэц/				
	• TV багцтай хэрэглэгч /нэг нэмэлт дэлгэц/				

Бүх үнэ тарифт НӨАТ тооцогдсон.

1.3 Захиалгат үйлчилгээний төрөл

Үйлчилгээний төлбөр	Нөхцөл	Сарын суурь хураамж нэхэмжлэх аргачлал
Багц солих	0₮	• Сард 1 удаа аль ч өдөр авах боломжтой
Хадгалах үйлчилгээ	5'000₮	<ul style="list-style-type: none"> • Шинэ хэрэглэгч нь хамгийн багадаа 3 сар үйлчилгээг ашигласны дараа хадгалуулах эрхтэй. • Хугацаатай нөхцөлөөр үйлчилгээ авсан хэрэглэгч заасан хугацаанд хадгалах үйлчилгээ авах боломжгүй. • Хадгалах хугацааг хуанлийн бүтэн сараар тооцох бөгөөд нэг удаад 12 сараас ихгүй хугацаагаар хадгалах боломжтой. • 12 сар хадгалсан үйлчилгээг 1 сар ашигласны дараа дахин хадгалуулах эрх үүснэ. • Хадгалах үйлчилгээ авах хэрэглэгч төлбөрийн үлдэгдэлгүй байна. • Хүсэлт гаргасан тухайн өдөрт нь гүйцэтгэж, үйлчилгээний эрхийг бүрэн хаана. • Хадгалах хугацаа дуусч үйлчилгээний эрх автоматаар нээгдэх үед төлбөрийн үлдэгдэлтэй болон төлбөр төлөх хугацаа хэтэрсэн бол төлбөрөөс хаалттай төлөвт шилжих эсвэл төлбөрөөс цуцлагдана.
Хэрэглэгчийн хүсэлтээр үйлчилгээ нээх	0₮	<ul style="list-style-type: none"> • Хэрэглэгч үйлчилгээгээ нээлгэх үед төлбөрийн үлдэгдэлтэй бол төлбөрөө бүрэн барагдуулах үүрэгтэй. • Хэрэглэгч нээлгэх хүсэлтээ дараах сувгаар өгөх боломжтой. <ul style="list-style-type: none"> • Үйлчилгээний салбарт; • 2288 үйлчилгээний нэгдсэн төв (Бусад сүлжээнээс 75952288 дугаарт)
		<ul style="list-style-type: none"> • Сольсон багцын сарын хураамжийг тухайн сард ашигласан өдөрт нь дүйцүүлэн тооцно. • Хэрэглэгч сарын 1-нээс хойш хадгалах үйлчилгээ авсан бол тухайн сарыг хадгалах хугацаанд оруулж тооцохгүй бөгөөд багцын сарын хураамжийг бүтэн нэхэмжилнэ. • Хадгалах хугацаа дуусахад дараа сарын 1-нд VOO үйлчилгээний эрх автоматаар нээгдэж тухайн сарын хураамжийг бүтэн нэхэмжилнэ. • Хэрэв тухайн сарын төлбөр бодогдож гараагүй байх /сар бүрийн 1-5-ны хооронд /тохиолдолд дараа сард хэрэглэгчээс тухайн сарын төлбөрийг нэхэмжлэх бөгөөд хэрэглэгч төлбөр нэхэмжлэгдсэн сарын 20-ны дотор төлбөрөө бүрэн барагдуулах үүрэгтэй. • Сарын дундуур үйлчилгээгээ нээлгэж байгаа тохиолдолд сарын хураамжийг сарын үлдсэн өдөрт дүйцүүлэн нэхэмжилнэ. • Төлбөрөөс хаалттай үйлчилгээг нээлгэж байгаа тохиолдолд тухайн сарын багцын хураамжийг бүтэн нэхэмжилнэ.